



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/409

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV Хуралдааны "Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" XIV/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны эрүүл мэндийг дэмжих, тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор ахмадын өргөө, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвд шаардлагатай тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажлыг зохион байгуулсугай.

2. Тус арга хэмжээний хүрээнд гэрээ байгуулан, хууль журмын дагуу зохион байгуулахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах 10,067,000 (арван сая жаран долоон мянган) төгрөгийг "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөл"-ийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 3,000,000 (гурван сая), "Ахмад настны хөгжил хамгаалал үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний зардлаас 5,000,000 (таван сая), "Эрүүл мэнд" хөтөлбөрийн зардлаас 2,067,000 (хоёр сая жаран долоон мянга) төгрөгийг санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ

